

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2023/03-НА-СТА-ОНА

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ХСУХАТАҮЗЗ	Хот суурингийн усан хангамжийн ариутгах татуургын арчлалт үйлчилгээний зохицуулах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
4. Аудитын тайлан	14
4.1. Ерөнхий зүйл	14
4.2. Материаллаг байдал	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	15
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
5.1 Залруулга	18
5.2 Төлбөрийн акт	18
5.3 Албан шаардлага	19
5.4 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	20



“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА А.АЛТАНСҮХ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 017-2023/03-НАСТАОМА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар он дамжсан дараа тайлангийн авлага үүсгэсэн, зардлыг судалгаа тооцоон дээр үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс батлагдсан зардлыг хэтрүүлсэн, цалин тэтгэмжийг давхардуулан олгосон зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 2,919,559.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,761,255.5 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 39.7 хувиар тасалсан байна.

Нийт зардлыг 3,025,383.4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,434,348.0 мянган төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөг 591,035.4 мянган төгрөгөөр хэмнэж 673,092.5 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

018020349

Аудитын гол асуудал

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 53,415.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БХБЯ-наас 38,338.8 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, аймгийн хөрөнгө оруулалтаар 401,957.5 мянган төгрөгийн худаг ухаж өрмийн машин, ухаалаг худгийн төхөөрөмж зэрэг нийт 440,296.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2022.01.01	2022.12.31
1.1	Эргэлтийн хөрөнгө	2,147,836,587.0	2,029,738,780.4
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	984,717.3	21,757,101.5
1.1.2	Дансны авлага	1,849,159,369.0	1,727,908,828.9
1.1.6	Бараа материал	289,558,005.2	280,072,850.1
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,134,495.5	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,147,836,587.0	2,029,738,780.4
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,525,801,017.8	9,417,118,543.6
1.2.2	Биет бус хөрөнгө	668,179,450.0	682,452,033.7
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,193,980,467.8	10,099,570,577.4
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,341,817,054.7	12,129,309,357.8
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	12,341,817,054.7	12,129,309,357.8
2.1	Өр төлбөр	1,714,770,714.3	1,727,059,236.2
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	1,714,770,714.3	1,727,059,236.2
2.1.1.1	Дансны өглөг	178,131,056.3	59,654,705.0
2.1.1.3	Татварын өр	769,180,526.5	828,650,368.7
2.1.1.4	НДШ - ийн өглөг	760,760,331.5	832,055,362.5
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,708,071,914.3	1,720,360,436.2
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	6,698,800.0	6,698,800.0
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,698,800.0	6,698,800.0
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,698,800.0	6,698,800.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,714,770,714.3	1,727,059,236.2
2.3	Эздийн өмч	10,627,046,340.5	10,402,250,121.6
2.3.1	Өмч: - төрийн	1,574,064,600.0	1,574,064,600.0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,326,522,257.7	10,326,522,257.7
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	208,993,441.2	657,289,718.9
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,482,533,958.4)	(2,155,626,455.0)
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,627,046,340.5	10,402,250,121.6
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,341,817,054.7	12,129,309,357.8

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Д/д	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022.01.01	2022.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,446,745,412.5	1,783,501,016.1
2	Борлуулалтын өртөг	2,444,430,259.2	2,365,987,677.8
3	Нийт ашиг (алдагдал)	2,315,153.3	(582,486,661.7)
8	Бусад орлого	21,650,600.0	21,650,600.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	93,451,723.6	88,036,073.9
12	Бусад зардал	15,954,418.9	24,220,361.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(85,440,389.2)	(673,092,496.6)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(85,440,389.2)	(673,092,496.6)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(85,440,389.2)	(673,092,496.6)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
					Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,574,064,600.0	10,326,522,257.7	186,177,656.0	(1,397,093,569.2)	10,689,670,944.5
3	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.0	10,326,522,257.7	186,177,656.0	(1,397,093,569.2)	10,689,670,944.5
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(85,440,389.2)	(85,440,389.2)
6	Өмчид гарсан өөрчлөлт			22,815,785.2		22,815,785.2
9	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,574,064,600.0	10,326,522,257.7	208,993,441.2	(1,482,533,958.4)	10,627,046,340.5
11	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.0	10,326,522,257.7	208,993,441.2	(1,482,533,958.4)	10,627,046,340.5
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(673,092,496.6)	(673,092,496.6)
14	Өмчид гарсан өөрчлөлт			448,296,277.8	-	448,296,277.8
17	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,574,064,600.0	10,326,522,257.7	657,289,718.9	(2,155,626,455.0)	10,402,250,121.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.01.01	2022.12.31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,257,060,131.3	1,905,518,761.1
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,235,409,531.3	1,883,868,161.1
	Татаас, санхүүжилтийн орлого	21,650,600.0	21,650,600.0
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,090,488,213.6	1,831,330,809.7
	Ажиллагчдад төлсөн	822,380,020.8	810,356,530.0
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	211,508,700.0	155,436,929.0
	Бараа материал худалдан авахад төлсөн	424,144,724.4	353,821,913.7
	Ашиглалтын зардалд төлсөн	359,877,057.0	269,480,499.2
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	71,353,510.6	80,261,230.8
	Хүүний төлбөрт төлсөн	8,119,339.2	4,068,303.0
	Татварын байгууллагад төлсөн	177,144,442.8	121,108,949.8
	Бусад мөнгөн зарлага	15,960,418.9	36,796,454.3
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	166,571,917.6	74,187,951.4
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	169,016,054.5	53,415,567.3
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	147,365,454.5	53,415,567.3
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	21,650,600.0	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(169,016,054.5)	(53,415,567.3)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,444,136.9)	20,772,384.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,428,854.2	984,717.3
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	984,717.3	21,757,101.5

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	2,919,559.46	1,761,255.51	1,158,303.95	60.32
	Үйл ажиллагааны орлого	м/төг	2,897,909.46	1,739,604.91	1,158,304.55	60.03
	Татаас санхүүжилт	м/төг	21,650.00	21,650.60	-0.6	100
	Бусад орлого	м/төг	-	-	-	-
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	3,025,383.44	2,434,348.00	591,035.44	80.46
1	ЦАЛИН	м/төг	896,185.60	810,356.53	85,829.07	90.42
2	НД-ийн шимтгэл	м/төг	240,822.60	142,324.04	98,498.56	59.09
3	ҮХ элэгдэл	м/төг	599,368.90	626,382.77	-27,013.87	104.5
4	Цахилгаан	м/төг	142,411.00	132,884.13	9,526.87	93.31
5	Үндсэн хөрөнгө худилдан авах	м/төг	103,800.00	53,415.56	50,384.44	51.46
6	Шатахуун	м/төг	96,000.00	80,261.23	15,738.77	83.6
7	Дулаан	м/төг	147,895.76	136,596.37	11,299.39	92.36
8	Түлш	м/төг			-	-
9	Буцалтгүй тусламж	м/төг	12,500.00	12,784.14	-284.14	102.2
10	Материал	м/төг	275,721.00	154,864.78	120,856.22	56.16
11	Холбоо	м/төг	14,000.00	12,576.09	1,423.91	89.82
12	Сургалт	м/төг	5,400.00	7,720.00	-2,320.00	142.9
13	Томилолт	м/төг	8,633.00	14,641.26	-6,008.26	169.6
14	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	1,202.10	1,202.10	-	100
15	Үл ХХ-ийн татвар	м/төг			-	-
16	НӨАТ, ХАОАТ, суутан	м/төг	141,937.28	166,562.18	-24,624.90	117.3
17	Ус ашигласны татвар	м/төг	8,200.00	8,000.00	200	97.5
18	Урсгал засвар	м/төг	198,100.00	15,997.30	182,102.70	8.07
19	Программ хангамжийн зардал	м/төг	1,800.00	5,338.80	-3,538.80	296.6
20	Аудитын зардал	м/төг	3,000.00	3,000.00	-	100
21	Даатгал	м/төг	5,940.00	1,000.00	4,940.00	16.83
22	Маркетингийн зардал	м/төг	40,186.20	24,220.36	15,965.84	60.27
23	Бусад зардал	м/төг	82,280.00	24,220.36	58,059.64	29.43
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	-105,823.98	-673,092.49	567,268.51	
4	Орлогын татвар (3*10%)	м/төг				
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	-105,823.98	-673,092.49	567,268.51	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ нь “Байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Гадаад худалдаа,

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ нь анх Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Урсгал ус” орон нутгийн өмчийн ХХК нэртэйгээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүрэгээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 21 дүгээр зүйл “Аймгийн чиг үүрэг”, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь “харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг*”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч аж ахуйн тооцоот зарчмаар ажилладаг байгууллагын онцлогт тохироогүй, борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, татаас санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	984.7	21,757.1	20,772.4
Авлага	1,849,159.4	1,727,908.8	(121,250.6)
Урьдчилж төлсөн зардал	8,134.5		(8,134.5)
Бараа материал	289,558.0	280,072.9	(9,485.1)
Үндсэн хөрөнгө	10,193,980.5	10,099,570.6	(94,409.9)
Нийт хөрөнгийн дүн	12,341,817.1	12,129,309.4	(212,507.7)
Өр төлбөр	1,714,770.7	1,727,059.2	12,288.5
Эздийн өмч	10,627,046.3	10,402,250.1	(224,796.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,341,817.1	12,129,309.4	(212,507.7)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 21,757.1 мянган төгрөг болж 20,772.4 мянган төгрөгөөр өссөн нь 1,905,518.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,884,746.4 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,727,908.8 мянган төгрөг болж 121,250.6 мянган төгрөгөөр буурсан нь төрөөс цэвэр бохир усны хөнгөлөлт чөлөөлөлтийн орлого орж ирснээс голлон шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдлийн 57.9 хувийг “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-аас, 2.9 хувийг Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгээс авах авлага эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардлын тооцоо дансны 2021 оны үлдэгдлээс 4,182.1 мянган төгрөгийг ажиллагсадтай холбоотой авлагын дансанд бүртгэж залруулснаас голлон шалтгаалж уг данс оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 280,072.9 мянган төгрөг болж 9,485.1 мянган төгрөгөөр буурсан нь 370,576.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 380,061.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 493,711.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 16,363.6 мянган төгрөгийн борлуулалтын программ хангамж, 3,318.2 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, 10,050.0 мянган төгрөгийн ухаалаг худгийн тоног төхөөрөмж, 23,683.7 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгсэл зэрэг нийт 53,415.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БХБЯ-наас 38,338.8 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, аймгийн хөрөнгө оруулалтаар 401,957.5 мянган төгрөгийн худгийн өрмийн машин, ухаалаг худгийн төхөөрөмж зэрэг нийт 440,296.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,727,059.2 мянган төгрөг болж 12,288.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 10,402,250.1 мянган төгрөг болж 224,796.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Сэлэнгэ аймгийн Засаг дарга “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын даргатай үр дүнгийн гэрээ байгуулж 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,919,559.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 3,025,383.4 мянган төгрөгөөр, алдагдлыг 105,823.9 мянган төгрөгөөр тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын 3 арга хэмжээнд 103,800.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,761,255.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,434,348.0 мянган төгрөгийн зардал гарган, 673,092.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,761,255.5 мянган төгрөг болж төлөвлөгөөг 1,158,304.0 мянган төгрөг буюу 39.7 хувиар тасалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,434,348.0 мянган төгрөг болж төлөвлөгөөг 591,035.4 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар хэмнэсэн нь орлогын бүрдүүлэлттэй холбоотойгоор төлөвлөсөн зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд 673,092.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлээгүй, ажил үйлчилгээ, бараа материалын үнийн өсөлт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн санхүүгийн тайлангийн тодруулга, цалингийн жагсаалтыг банкны тамга тэмдгээр баталгаажуулах, цахим банкаар хийсэн зарлагын гүйлгээний нотлох баримтыг хавсаргах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэнд анхаарч ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, аудиторын туслах Б.Улам Оргил нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,553,836.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,538.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах, албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 17 төрлийн 228 мэдээллээс 52 мэдээллийг хугацаа хоцроож, 74 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 13 удаа хугацаа хоцроож, 20 удаа огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 17 удаа хугацаа хоцроосон,
- Бусад мэдээллийг 22 удаа хугацаа хоцроож, 25 удаа огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аймгийн ОНӨГ-ын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 105 дугар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/1696 албан бичгээр Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж “Шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй” байх чиглэл хүргүүлсэн байна.

“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Хэвлэл захиалга, шуудан холбооны зардлыг 1,423.6 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Халаалт, дулааны зардлыг 15,738.8 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Маркетинг, менежментийн зардлыг 15,965.8 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Айл өрхийн авлагыг 125,432.7 мянган төгрөгөөр бууруулсан,
- Хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргаагүй, өөрийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл болон согтууруулах ундаа худалдан авахыг хориглох зэргээр хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 194 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,230.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1,290.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, төлөвлөгөөнд тусгагдаагүй 14,800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчил өгсөн албан шаардлага, 62,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	2,230.8	1	2,230.8	100.0
Албан шаардлага	2	14,800.0	1	14,800.0	50.0
Зөвлөмж	1	62,400.0	1	62,400.0	100.0
Нийт дүн	4	79,430.8	3	79,430.8	75.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

4.6.1. Нийгмийн даатгалын шимтгэлийн 832,055.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаагаас шалтгаалан нийгмийн даатгалын сангаас даатгуулагчид олговол зохих 3,145.0 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмж, 12,842.7 мянган төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 27,609.5 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж зэрэг нийт 43,597.2 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь “Ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч бүрэн хариуцаж төлнө” гэсэн заалтын дагуу байгууллагаас төлсөн нь алдагдлын хэмжээнд нөлөөлсөн байна.

4.6.2. ХСУСАТАҮЗЗ-ийн шийдвэрээр цэвэр, бохир усны үйлчилгээний хөлс, усны үйлчилгээний суурь хураамжийг 2014 онд нэмснээс хойш 5 жилийн хугацаанд дахин нэмээгүй байна. Энэ хугацаанд цалин хөлс, татвар, шимтгэлийн зардал, сэлбэг, түүхий эд, цахилгаан, дулааны үнэ өсч байгаа нь тус байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дүнг бий болгож жилээс жилд өр төлбөр, алдагдлын хэмжээ нэмэгдэж байгааг анхаарч цэвэр, бохир усны үйлчилгээний хөлс, усны үйлчилгээний суурь хураамжийг нэмэх асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

4.6.3. Тус байгууллага нь Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч аж ахуйн тооцоот зарчмаар ажилладаг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир өөрийн онцлогт тохирсон НБББББ-ийг боловсруулж мөрдөх нь зүйтэй юм.

4.6.4. Ерөнхий нягтлан бодогч Г.Сувд нь ажил үүргийн хуваарийн дагуу борлуулалт, байгууллага хоорондын тооцоо, цалин хөлсний тооцоог хариуцахаас гадна эдийн засагчийн ажил үүргийг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, ерөнхий нягтлан бодогчийн зүгээс бүртгэлээр хяналт тавих үүрэг сулрах, ажил цалгардах эрсдэлийг бий болгож байна. Иймд

ачааллыг тэнцвэржүүлж хяналт тавих чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах нь зүйтэй юм.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитаар нийт 24,933.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- 4,182.1 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг “урьдчилж төлсөн зардал” дансанд тайлагнасан,
- 2023 оны ээлжийн амралтын цалин 4,388.1 мянган төгрөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- Худалдан авсан 16,363.6 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн зарлага хэсэгт тусгаагүй ,

Аудитаар нийт 41,275.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 27,020.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 14,254.6 мянган төгрөгийн албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Өглөг, авлагыг хянаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүйгээс сэлбэг, материал худалдан авахаар дараа тайлангаар мөнгө авсан инженер С.Ганцоож 4,416.6 мянган төгрөгийн, М.Отгонбаяр 1,053.2 мянган төгрөгийн, Г.Цэнд-Аюуш 1,188.9 мянган төгрөгийн, А.Алтанзул 5,421.9 мянган төгрөгийн, механик Ц.Нэмэхбаатар 4,722.7 мянган төгрөгийн, эд хариуцагч Д.Баярчимэг 9,763.1 мянган төгрөгийн зэрэг нийт 26,566.3 мянган төгрөгийн он дамжсан үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн үлдэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ХЧТА тэтгэмж авсан 4 ажилтанд 454.5 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх “Хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. 2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож, төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулаагүйгээс албан томилолтын зардлыг 6,000.2 мянган төгрөгөөр, сургалт семинарын зардлыг 2,320.0 мянган төгрөгөөр, программ хангамжийн зардлыг 3,538.8 мянган төгрөгөөр зэрэг нийт 11,859.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд нэр бүхий 10 албан тушаалтны ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажилласан хугацааны цалин 2,395.6 мянган төгрөгийг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон нь үйлдвэрлэлийн үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “*Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдыг биеэр нөхөн амруулж, цалингийн давхардал үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлангийн тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*”, 8.1.5 дахь “*санхүүгийн тайлангийн тодруулга*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж байх

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Цалингийн цэсээр тооцогдсон цалинг ажилчдын харилцах дансанд шилжүүлсэн жагсаалт баримтыг банкны тамга тэмдгээр баталгаажуулж

санхүүгийн баримтад хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн жагсаалтыг банкны тамга, тэмдгээр баталгаажуулж байх.

Илрүүлэлт 2: Цахим банкаар хийсэн зарлагын гүйлгээнд тухайн харилцагчийн нэхэмжлэх, зарлагын баримтыг бус нярав, инженерүүд бэлэн мөнгөний хүсэлт бичиж хавсаргаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Зарлагын гүйлгээг тухайн харилцагчийн нэхэмжлэх, орлогын баримтаар баримтжуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд урьдчилгаа цалинг “урьдчилж төлсөн зардал” дансанд бүртгэсэн	1	4,182.1			1	4,182.1	1	4,182.1				
2023 оны ээлжийн амралтын нөхөн олговрыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,	1	4,388.1			1	4,388.1	1	4,388.1				
Худалдан авсан биет бус	1	16,363.6			1	16,363.6	1	16,363.6				

"Сэлэнгэ Цэнгэг ус" ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн зарлага хэсэгт тусгаагүй												
Дүн	3	24,933.8			3	24,933.8	3	24,933.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дараа тайлангийн тооцоог цаг хугацаанд нь хянаагүйгээс он дамжсан авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан	1	26,566.3	1	26,566.3								
Төлөвлөгдсөн зардлыг хэтрүүлсэн	1	11,859.0			1	11,859.0						
ХЧТА болон цалин давхардуулан олгосон	1	454.5	1	454.5								
Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс цалин давхардуулан олгосон	1	2,395.6			1	2,395.6						
Санхүүгийн тайланд тодруулга хийгээгүй	1						1					
Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй	1						1					
Цалин олгосон жагсаалтыг банкны тамга тэмдгээр баталгаажуулаагүй	1						1					
Дүн	7	41,275.4	2	27,020.8	2	14,254.6	3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй хэлбоотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	52				52			
Огт мэдээлээгүй	74				74			
Дүн	126				126			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								